



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/69

Мандалговь

**Т.Урансайханыг Боловсрол шинжлэх ухааны
газрын Цахим технологи, мэдээллийн сүлжээ
хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Боловсрол, шинжлэх ухааны газрын Цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Тунсаг овогтой Урансайхан 58.8 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.


Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Т.Урансайханы холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2023 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



**Боловсрол шинжлэх ухааны газрын Цахим технологи,
мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн Т.Урансайханы тухай дүгнэлт**

1. Т.Урансайхан нь 1994 онд Дундговь аймгийн Өлзийт суманд төрсөн. 29 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2012-2016 онд МУИС-ийг менежмент мэдээллийн систем мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.
3. Т.Урансайханы тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Боловсрол шинжлэх ухааны газрын Цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ